



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ

ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧИЙН ГАРЫН АВЛАГА

20 сая

хүртэлх төгрөг
даатгагдсан

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- Хадгаламжийн даатгалын тогтолцооны ач холбогдол
- Хадгаламжийн даатгалд хамрагдсан банкууд

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Эрхэм зорилго
- Үндсэн үйл ажиллагаа

ДААТГАГДСАН ХАДГАЛАМЖ

- Даатгагдсан хадгаламж
- Даатгагдсан хадгаламж эзэмшигч
- Нөхөн төлбөр олгохоос түдгэлзүүлэх хадгаламж

ДААТГАЛД ҮЛ ХАМААРАХ ХАДГАЛАМЖ

- Даатгалд үл хамаарах хадгаламж
- Даатгалд хамрагдахгүй хадгаламж эзэмшигч

НӨХӨН ТӨЛБӨР

- Нөхөн төлбөрийг хэрхэн олгох вэ?
- Нөхөн төлбөр авах хэлбэр, хугацаа
- Нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцох вэ?
- Нөхөн төлбөр авахад бүрдүүлэх шаардлагатай бичиг баримт


САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Банк албадан татан буугдсан тохиолдолд Хадгаламжийн даатгалын сангаас таны тухайн банканд харилцах, хадгаламжийн нийт 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн олгох үйл ажиллагааг хэлнэ.

Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталснаар Монгол Улсад Хадгаламжийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх болсон.



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ АЧ ХОЛБОГДОЛ



Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах



Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Иргэдийн банканд итгэх итгэлийг бэхжүүлэх

Хадгаламжийн даатгалд хамрагдахын тулд харилцагч та ямар нэгэн төлбөр хураамж төлөхгүй бөгөөд банк нь хуульд заасны дагуу харилцагчдынхаа өмнөөс даатгалын хураамжийг төлдөг. *(Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, 13 дугаар зүйлийн 13.1 дэхь хэсэг)*

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны бүх банк хадгаламжийн даатгалд хамрагдсан байдаг. Өөрөөр хэлбэл та хэд хэдэн банканд харилцах, хадгаламжийн данс эзэмшдэг гэж үзвэл банк тус бүр дээрх таны харилцах, хадгаламжийн нийт 20 сая хүртэлх төгрөг даатгагдаж, хамгаалагдсан гэж ойлгож болно.

ГИШҮҮН БАНКУУД





ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

Хадгаламжийн даатгалын корпораци нь 2013 Оны 6 дугаар сард үүсэн байгуулагдсан ба “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийн хүрээнд хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Монгол улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, банкны салбарын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1



Хадгаламжийн даатгалын санг удирдах

2



Даатгалын хураамжийг санд төвлөрүүлэх

3



Нөхөн төлбөр олгох

4



Санхүүгийн дэмжлэг үзүүлэх



Хадгаламжийн даатгалын корпораци нь 2013 онд Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбоонд 72 дахь үндсэн гишүүнээр элсэн орж, дэлхийн бусад орны туршлага мэдлэгээс суралцах, харилцан мэдээлэл солилцох зэргээр холбооны гишүүн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбоонд дэлхийн 100 гаруй орны хадгаламжийн даатгалын байгууллагууд элссэн байдаг.

Монголын хадгаламжийн даатгалын корпорацийг “Банкыг өөрчлөн байгуулах, нөхөн төлбөрт гаргасан амжилт”-аар Олон Улсын Хадгаламжийн Даатгагчдын Холбооноос 2014 оны шилдэг байгууллагаар шалгаруулсан.



ДААТГАГДСАН ХАДГАЛАМЖ



ДАРААХ ХАДГАЛАМЖ ДААТГАГДАЖ ХАМГААЛАГДСАН

Хадгаламж эзэмшигчийн тухайн банканд дахь харилцах, хадгаламжийн нийт 20 сая хүртэлх төгрөг хадгаламжийн даатгалаар хамгаалагдсан.

Үүнд:

- Хугацаатай, хугацаагүй хадгаламжийн данс;
- Харилцах данс /цалин, тэтгэвэр, карт гэх мэт/;
- Гадаад валютын харилцах, хадгаламжийн данс*

** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэхь хэсэгт заасны дагуу энэ хуулийн үйлчлэх хугацаанд банкны нийт гадаад валютын харилцах, хадгаламж хадгаламжийн даатгалд хамрагдахгүй.*

ДАРААХ ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛААР ХАМГААЛАГДСАН

- Иргэн болон хуулийн этгээд;
- Насанд хүрээгүй хадгаламж эзэмшигч;
- Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн болон үйл ажиллагаагаа эрхэлж буй гадаадын хуулийн этгээд.

НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ХАДГАЛАМЖ

- Эрх бүхий байгууллагын зүгээс битүүмжилсэн;
- Тухайн банкны зүгээс битүүмжилсэн;

Түдгэлзүүлсэн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийн 20 сая хүртэлх төгрөгийн дүнг нөхөн төлбөр олгох банканд шилжүүлнэ.

Хадгаламжийн данс болон хадгаламж эзэмшигчтэй холбоотой дараах тохиолдолд нөхөн төлбөр олгохыг дор дурьдсан хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

- Эрх бүхий байгууллагаас эрх зүйн аливаа хэрэг, маргаан үүсгэсэн тохиолдолд тухайн эрх зүйн хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаагаар;
- Хадгаламжийн өв нээгдээгүй бол өв нээгдэх хүртэл хугацаагаар;
- Хадгаламж эзэмшигч эрх зүйн чадамжгүй болсон, эрх зүйн чадамжийг хязгаарласан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан бол шүүхийн шийдвэр хүчингүй болох хүртэл хугацаагаар;
- Иргэнийг сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан бол шүүхийн шийдвэр хүчингүй болох хүртэл хугацаагаар;
- Гадаад улсад удаан хугацаагаар зорчсон бол Монгол Улсад ирэх хүртэл хугацаагаар;
- Хуульд заасан бусад түдгэлзүүлэх шаардлагатай үндэслэл байвал тухайн хуульд заасан нөхцөл арилах хүртэл хугацаагаар, (онц байдал зарлах, нийтийг хамарсан өвчин, байгалийн гамшиг, дайн, бусад давагдашгүй нөхцөл байдал гэх мэт бусад хуульд заасан нөхцлүүд хамаарна).

Дээр дурдсан нөхөн төлбөр олгохоос түдгэлзүүлсэн хугацаа дууссан буюу хүчингүй болсон тохиолдолд хадгаламж эзэмшигч нөхөн төлбөр олгох банканд хандаж, даатгалын нөхөн төлбөрөө авна.

ДААТГАЛД ҮЛ ХАМААРАХ ХАДГАЛАМЖ



ДАРААХ ХАДГАЛАМЖ ДААТГАЛД ХАМААРАХГҮЙ

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;
- Нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл;
- Нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь хэсэг/*
- Даатгагдсан хадгаламжийн дээд хэмжээ 20 сая төгрөгөөс илүү гарсан мөнгөн дүн;

ДАРААХ ЭТГЭЭДИЙН ХАДГАЛАМЖ ДААТГАЛД ХАМААРАХГҮЙ

- Банк;
- Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага;
- Эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан;
- Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд;
- Даатгалын тохиолдол бий болохоос өмнөх гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага;
- Монголбанкны хяналт, шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж эзэмшигч. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг/*

НӨХӨН ТӨЛБӨР



НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН ОЛГОХ ВЭ?

Хадгаламжийн даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-аар зохицуулагдана.

Банк албадан татан буугдсан тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпорациас хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөрийг сонгогдсон нөхөн төлбөр олгох банкаар дамжуулан олгоно.

Нөхөн төлбөр олгох банкыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо Монголбанктai зөвшилцөн сонгон шалгаруулдаг. Хадгаламж эзэмшигч сонгон шалгаруулсан банкны салбар, тооцооны төвүүдээс даатгалын нөхөн төлбөрөө авах боломжтой.

НӨХӨН ТӨЛБӨР АВАХ ХЭЛБЭР, ХУГАЦАА

Хадгаламж эзэмшигч нөхөн төлбөрийг бэлнээр болон бэлэн бусаар авах боломжтой. Ингэхдээ нөхөн төлбөр олгож буй банкны салбар, тооцооны төв дээр очиж, банкны ажилтны хэвлэж өгсөн “Нэхэмжлэлийн маягт” дээрх мэдээлэлтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд баталгаажуулж гарын үсэг зурна. Үүний дараа банкны ажилтан нөхөн төлбөрийг олгоно.

Нэхэмжлэлийн маягт нь тухайн хадгаламж эзэмшигчийн мэдээлэл болон татан буугдсан банканд эзэмшдэг нийт харилцах, хадгаламжийн мэдээлэл, 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээлийн мэдээлэл, нөхөн төлбөрийн хэмжээ, хадгаламж эзэмшигчийн мэдүүлэг зэрэг мэдээллийг агуулсан байдаг.

Бэлэн бусаар авах тохиолдолд:

- Хэрэв та нөхөн төлбөр олгож буй банканд данстай бол тухайн данс руу шилжүүлэн авч болно;
- Хэрэв та нөхөн төлбөр олгож буй банканд дансгүй бол шинээр данс нээлгэж, тухайн дансандаа шилжүүлэн авч болно;
- Нөхөн төлбөр олгож буй банкнаас өөр бусад банканд дахь данс руу шилжүүлэн авч болно.

Хадгаламж эзэмшигч банк албадан татан буугдсан өдрөөс хойш 3 жилийн дотор нөхөн төлбөрөө нэхэмжлэн авах эрхтэй. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэхь хэсэг/*

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ХЭРХЭН ТООЦОХ ВЭ?

Банк албадан татан буугдахад Хадгаламжийн даатгалын корпорациас хадгаламж эзэмшигчийн тухайн банканд дахь нийт хадгаламжийн 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн төлнө. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэхь хэсэг/*

Нөхөн төлбөрийн хэмжээг тооцож олгохдоо банкны татан буугдсан өдрийн байдлаарх хадгаламж эзэмшигч бүрийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл дүн дээр гэрээний дагуу хуримтлагдсан хүүгийн дүнг нэмж, хэрэв тухайн банканд 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн чанаргүй зээлтэй байвал тухайн зээлийг хүүгийн хамт хасч, үлдсэн мөнгөн дүнгийн 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн төлнө.

$$[\text{хадгаламж}^* + \text{хүү}] - [\text{зээл}^{**} + \text{хүү}] \leq 20 \text{ сая}$$

**Харилцах болон хадгаламж*

*** Зөвхөн 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн зээл*


Таны банкн дахь хадгаламжийн дүн 20 сая төгрөгөөс илүү гарсан тохиолдолд 20 сая хүртэлх төгрөгийг Хадгаламжийн даатгалын корпорациас бүрэн нөхөн олгох ба 20 сая төгрөгөөс илүү гарсан мөнгөн дүнг татан буугдсан банкны эрх хүлээн авагчаас нэхэмжлэн авах боломжтой.

Банкны эрх хүлээн авагч нь Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан төлбөр барагдуулах дарааллын дагуу таны мөнгийг шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хадгаламж эзэмшигч та татан буугдсан банканд гадаад валютын данстай* бол тухайн банкны татан буугдсан өдрийн Монголбанкны ханшаар төгрөг рүү шилжүүлэн тооцуулж, нөхөн төлбөрөө авна.

/Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэхь хэсэг/

** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэхь хэсэгт заасны дагуу энэ хуулийн үйлчлэх хугацаанд гадаад валютын хадгаламжид даатгалын нөхөн төлбөр олгохгүй.*



Банкыг нэгтгэх, нийлүүлэх болон банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлсэн банканд 6 сарын хугацаанд даатгалын тохиолдол бий болвол хадгаламж эзэмшигчдэд банк тус бүр дэхь хадгаламжийн 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн төлнө.

Энэ хугацаа дуусахаас 1 сарын өмнө банк танд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухайн хугацаа өнгөрсөн тохиолдолд хоёр банкн дахь нийт хадгаламжийг нэгтгэн 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн төлнө.

/Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, 17.6 дахь хэсэг/

Дангаараа эзэмшдэг хадгаламж



Дангаар эзэмшдэг нийт дансыг банк татан буугдсан өдрийн байдлаар нэгтгэн, нийлбэр дүнгээс даатгалын нөхөн төлбөрийг тооцно. Даатгагдсан хадгаламжийн нийт дүн 20 сая төгрөгөөс илүүгүй байна. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг/*

Жишээ №1

Данс эзэмшигчийн нэр: Анар		
Хадгаламжийн төрөл	Дансны төрөл	Дансны нийт үлдэгдэл /төгрөг/
Хугацаатай хадгаламж	төгрөг	30,000,000
Хугацаагүй хадгаламж	төгрөг	4,000,000
Харилцах данс	төгрөг	500,000
Нийт дансны үлдэгдэл:		34,500,000
Анарын даатгагдсан хадгаламжийн дүн		20,000,000
Даатгалд хамаарахгүй хадгаламжийн дүн **		14,500,000

Тайлбар: Иргэн Анар татан буугдсан А банканд төгрөгийн хугацаатай, хугацаагүй хадгаламжийн болон харилцах дансуудад нийт 34,500,000 төгрөгийн үлдэгдэлтэй байв. Тэрээр Хадгаламжийн даатгалын корпорациас нийт 20 сая хүртэлх төгрөгийн нөхөн төлбөрийг авах эрхтэй.

****14,500,000 төгрөг нь даатгалд хамаарахгүй тул иргэн Анар татан буугдсан А банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилж авах боломжтой.**

Хамтарсан данс эзэмшигчтэй хадгаламж



Хамтарсан данс эзэмшигчдэд төлөх нийт даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ 20 сая хүртэлх төгрөг байна. Хамтарсан данс эзэмшигчид хамт ирж нөхөн төлбөр авах шаардлагатай.

Хамтарсан данс дахь эзэмшлийн хувь нь тэнцүү биш гэдгийг нотолсон баримт гаргаснаас бусад тохиолдолд хамтарсан данс эзэмшигчдэд нөхөн төлбөрийг тэнцүү хуваан тооцож олгоно. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэхь хэсэг/*

Жишээ №2

Данс эзэмшигчийн нэр: Бат		
Хамтарсан данс эзэмшигчийн нэр: Туяа		
Хадгаламжийн төрөл	Дансны төлөв	Дансны нийт үлдэгдэл /төгрөг/
Хугацаатай хадгаламж	хамтарсан	24,000,000
Харилцах	-	600,000
Нийт дансны үлдэгдэл:		24,600,000
Батын даатгагдсан хадгаламжийн дүн		10,600,000
Туяагийн даатгагдсан хадгаламжийн дүн		10,000,000
Даатгалд хамаарахгүй хадгаламжийн дүн **		4,000,000

Тайлбар: Татан буугдсан А банканд иргэн Бат харилцах, хадгаламжийн данс эзэмшдэг. Өөрийн харилцах дансандаа 600,000 төгрөгтэй, мөн тэрээр иргэн Туяатай 24,000,000 төгрөгийн хадгаламжийг хамтран эзэмшдэг. Бат, Туяа нар хамтран эзэмшдэг хувь хэмжээгээ тэнцүү биш гэдгийг нотлох баримт гаргаагүй тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпорациас тэдэнд нийт 20 сая хүртэлх төгрөгийн нөхөн төлбөрийг тэнцүү хувааж олгоно.

***4,000,000 төгрөг даатгалд хамаарахгүй тул татан буугдсан банкны эрх хүлээн авагчаас нэхэмжлэн авах боломжтой.*

Хуульд зааснаар хадгаламж эзэмшигчийн дангаараа болон хамтарсан дансны эзэмшдэг даатгагдсан хадгаламжийн нийт дүн 20 сая төгрөгөөс илүүгүй байна.

Насанд хүрээгүй иргэний хадгаламж



Насанд хүрээгүй хадгаламж эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрх тухайн хадгаламжийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж байгаагаар хязгаарлагдахгүй. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг/*

Жишээ №3

Данс эзэмшигчийн нэр: Болд /насанд хүрээгүй хүүхэд/ Хамтарсан данс эзэмшигчийн нэр: Мөнхөө /Болдын аав/		
Хадгаламжийн төрөл	Дансны төлөв	Дансны нийт үлдэгдэл /төгрөг/
Хүүхдийн хадгаламж	хамтарсан	30,000,000
Нийт дансны үлдэгдэл:		30,000,000
Болдын даатгагдсан хадгаламжийн дүн		20,000,000
Мөнхөөгийн даатгагдсан хадгаламжийн дүн		10,000,000

Тайлбар: Болд хүү татан буугдсан А банканд 30 сая төгрөгийн хадгаламжтай ба түүний аав Мөнхөө хамтран эзэмшдэг. Хадгаламжийн даатгалын корпораци Болд хүүд тухайн банкин дахь түүний хадгаламжийн 20 сая хүртэлх төгрөгийг нөхөн олгох бөгөөд насанд хүрээгүй тул хамтран эзэмшигч болох аав Мөнхөө нь хүүгийнхээ өмнөөс хадгаламжийн даатгалын нөхөн төлбөрийг авах эрхтэй. Мөн тэрээр тухайн хадгаламжийн хамтарсан данс эзэмшигч учир үлдэгдэл 10 сая төгрөгийг авах эрхтэй ба иргэн Мөнхөөгийн татан буугдсан А банканд дахь харилцах, хадгаламжийн нийт нөхөн төлбөрийн хэмжээ 20 сая төгрөгөөс илүүгүй байна.

Өв залгамжлалтай хадгаламж



Өв залгамжлалаар даатгалын нөхөн төлбөр авах тохиолдолд өвлөгч нь өөрийн нэр дээр хадгалуулсан хадгаламж, өвлөгдсөн хадгаламж тус бүрд даатгалын нөхөн төлбөрийг авна. */Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг/*

Өв залгамжлагч өөрийн дангаар эсхүл хамтран эзэмшдэг хадгаламжид ноогдох нөхөн төлбөрийг тусдаа авна.

Жишээ №4

Хадгаламж эзэмшигчийн нэр: Тамир		
Хадгаламжийн төрөл	Дансны төлөв	Дансны нийт үлдэгдэл /төгрөг/
Харилцах	-	500,000
Хугацаатай хадгаламж	Өв залгамжлал	30,000,000
Нийт дансны үлдэгдэл:		30,500,000
Тамирын дансны даатгагдсан хадгаламжийн дүн		500,000
Өв залгамжлалаар авах даатгагдсан хадгаламжийн дүн		20,000,000
Даатгалд хамаарахгүй хадгаламжийн дүн **		10,000,000

Тайлбар: Хадгаламж эзэмшигч Тамир татан буугдсан А банканд харилцах данс болон өв залгамжлалын эрхтэй хадгаламжийн данс эзэмшдэг. Хадгаламжийн даатгалын корпорациас Тамирын эзэмшдэг харилцах дансны 20 сая хүртэлх төгрөгийг олгохоос гадна өв залгамжлах эрхтэй хадгаламжийн 20 сая хүртэлх төгрөгийг тус тусад нь тооцож нөхөн төлбөр олгоно. Өөрөөр хэлбэл, Тамир нийт 20,500,000 төгрөгийн нөхөн төлбөр авна. **10,000,000 төгрөг нь хадгаламжийн даатгалд хамаарахгүй тул татан буугдсан банкны эрх хүлээн авагчаас нэхэмжлэн авах боломжтой.

НӨХӨН ТӨЛБӨР АВАХАД БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТ



Хадгаламж эзэмшигч нөхөн төлбөр олгох банкны салбар, тооцооны төв дээр дараах бичиг баримттай ирж нөхөн төлбөр авна.

Хадгаламж эзэмшигч иргэн бол:

- Иргэний үнэмлэх;
- Гадаад улсын иргэн бол гадаад паспорт, эсхүл Монгол Улсад оршин суух үнэмлэх;

Хадгаламж эзэмшигч хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, хуулийн этгээдийг төлөөлөгч этгээдийн иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол гадаад паспорт, эсхүл Монгол Улсад оршин суух үнэмлэх;
- Дансан дахь мөнгөн хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтанд эрх олгосон бол: итгэмжлэл, эсхүл тушаал, шийдвэр гэх мэт.

Хадгаламж эзэмшигч өв залгамжлагч бол:

- Өв залгамжлагч нь өөрийгөө хууль ёсны өв залгамжлагч мөн болохыг нотлох бичиг баримт;
- Гэрээслэлээр өвлөх эрхийн гэрчилгээ;
- Өв залгамжлагч өргөдөл гаргана; /өргөдлийн маягтыг зааврын дагуу бөглөх/.

Хадгаламж эзэмшигч насанд хүрээгүй бол:

- Хүүхдийн төрсний гэрчилгээ;
- Насанд хүрсэн хамтран эзэмшигчийн иргэний үнэмлэх;
- Хадгаламжийн дэвтэр, эсхүл хадгаламжийн гэрээ;
- Хамтран эзэмшигч өргөдөл гаргана /өргөдлийн маягтыг зааврын дагуу бөглөх/.

Хадгаламж эзэмшигч итгэлцлийн дансны үйлчилгээ ашигладаг бол:

- Иргэн бол талуудын иргэний цахим үнэмлэх;
- Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Талуудын хооронд байгуулсан хэлцлийн гэрээ;
- Тухайн банктай байгуулсан итгэлцлийн үйлчилгээний гэрээ;
- Өргөдөл гаргах /өргөдлийн маягтыг зааврын дагуу бөглөх/.

Хадгаламж эзэмшигч нас барсан бол:

- Нас барсны гэрчилгээ;
- Нас барсан этгээдийн хууль ёсны өв залгамжлагч мөн болохоо нотлох баримт бичиг;
- Өвлөх эрхийн гэрчилгээ;
- Өв залгамжлагчийн өргөдөл /өргөдлийн маягтыг зааврын дагуу бөглөх/.

Хамтарсан данс эзэмшигчтэй бол:

- Иргэн бол талуудын иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Хамтарсан дансан дахь эзэмшлийн хувь нь тэнцүү биш тохиолдолд эзэмшлийн хувь өөр өөр болохыг нотлох баримт бичиг;
- Талуудын өргөдөл /өргөдлийн маягтыг зааврын дагуу бөглөх/.



Нөхөн төлбөр олгох банкны дотоод журамд заасан бусад бичиг баримтыг нэмэлтээр бүрдүүлнэ.

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ



Санхүүгийн дэмжлэг гэж банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн авч байгаа банканд актив, пассивын зөрүүг нөхөх, эсхүл тусгай зориулалтын банкны өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорациас мөнгөн хөрөнгө шилжүүлэхийг хэлнэ.

Өөрөөр хэлбэл банк төлбөрийн чадваргүй болсон эсхүл үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн банкны даатгалд хамрагдсан хадгаламжийг үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа өөр банк руу шилжүүлж, Хадгаламжийн даатгалын корпорациас шаардлагатай хөрөнгийг санхүүгийн дэмжлэг хэлбэрээр шийдвэрлэх үйл ажиллагаа юм.

Ингэснээр хүндрэлд орсон банкны хадгаламж эзэмшигч өөр банкны харилцагч болох төдийгүй өмнө банкнаас авч байсан бүх үйлчилгээгээ хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлдэг давуу талтай, олон улсын шалгарсан аргачлал юм. Ийнхүү хадгаламжийг шилжүүлснээр хадгаламж эзэмшигчийн даатгагдсан мөнгийг хамгаалж байгаа учир Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс нөхөн төлбөрийг олгосонд тооцно.



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Нарны зам 91, Санроуд байр 4 давхарт

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авна уу

Цахим хуудас: www.dicom.mn

Цахим шуудан: contact@dicom.mn

Фэйсбүүк хуудас: facebook.com/DICOM.MN/



7000-8448

Даваа-Баасан **08:30 - 17:30**



11-370-000

Даваа-Баасан **09:00 – 18:00**